

2020 оны 2дугаар улиралын санхүүгийн

үйл ажиллагааны жилийн тайлан

Чойбалсан хот

2020,06.30

“Дорнод Авто зам” Хувьцаат компани нь аймгийнхаа нутаг дэвсгэрт байгаа улсын чанартай асфальт бетон хучилттай 160 км зам, ердийн хөрсөн 819,92 км зам, хайрган хучилттай 291,17 км зам, сайжруулсан хөрсөн 13,66 км зам нийт 1284.75км авто замын арчлалтын хариуцан гүйцэтгэдэг бөгөөд эдгээр замууд нь ОХУ,БНХАУ-тай 7 чиглэлээр холбогддог, улс хоорондын авто замын тээвэрт чухал үүрэг ач холбогдолтой. Халхгол, Хэрлэнгийн доод дээд 2 гүүр,Улзын голын нийт 4 бетон хийц бүхий 864 у/м гүүрүүдийн арчлалт хамгаалалтын ажлыг 4 гүүр хамгаалагч хариуцан ажиллаж байна.

Манай компани нь 2020 оны 2р байдлаар 132.1 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 132.0 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 0.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан. 2020 онд Зам,Тээврийн Хөгжлийн Яамтай хийсэн гэрээний дагуу улсын чанартай зам засвар арчлалтын 942,0 сая төгрөгийн ажил хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. 2 дугаар улиралын байдлаар гэрээний гүйцэтгэл 41,2 хувьтай байна. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, ажлыг гэрээт хугацаандаа бүрэн хийж гүйцэтгэх, техникийн бүрэн бүтэн байдал,сэлбэг шатахуун,материалаар тасралгүй ханган ажиллах , ажлыг жигд явуулахын тулд график төлөвлөгөө гарган, цаг тухайд нь гүйцэтгэхээр төлөвлөн ажилладаг. Мөн авто зам, замын байгууламжийн урсгал засвар,арчлалтын ажлыг холбогдох норм,дүрэм,стандарт, журмыг баримтлан, гэрээнд болон график төлөвлөгөөнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан техникийн шаардлагын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэж,авто зам,замын байгууламжийн байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Компани дээрхи ажлуудыг хийж гүйцэтгэхдээ 20 ажиллагсадтайгаар зам засвар арчлалтын ажилд ажиллаж, цалингийн зардалд 69,6 сая төгрөг, НДШимтгэлд 5,3 сая төгрөг, материал түүхий эд худалдан сэлбэг хэрэгсэл болон шатахууны зэрэг шууд үйлдвэрлэлийн зардалд 55,9 гаруй сая төгрөгийг зарцуулав. Мөн НӨАТатварт 9,8 сая төгрөг,бусад татвар шимтгэлд 0 сая төгрөгийн татвар төлөлтийг тооцож аймаг орон нутгийн татварт төвлөрүүлэн ажиллав.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг НББОУС-ын дагуу хөтлөн, баланс,орлого үр дүнгийн тайлан,өмчийн өөрчлөлтийн тайлан,мөнгөн гүйлгээний тайлан,бусад тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланг бэлтгэн компанийн удирдлагыг санхүүгийн иж бүрэн мэдээлэлээр ханган ажиллаж байна.

Тайлан бичсэн:

“Дорнод Авто зам” Хувьцаат компанийн
Нягтлан бодогч Ц.ОТГОН

